

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХИ ХУУЛЬ ЗҮЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2017 оны 12 дугаар  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
 хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Л.Болд**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2017 оны 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хороо 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хуралдаж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.3.5, 32.3.7 дахь заалтад заасан журмын дагуу Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсгээс „, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй” гэснийг хасах өөрчлөлтийг тусгасан Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд, уг хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж, батлуулах нь зүйтэй гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэйгээр дэмжсэн.

Хууль зүйн байнгын хорооноос боловсруулсан Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаархи Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, уг хуулийн төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**

**Ш.РАДНААСЭД**



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн ", эсхүл хөгжлийн бэрхшээлтэй" гэснийг хассугай.

Гарын үсэг